



# УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1984 оны 5 дугаар  
сарын 29-ны өдөр

Дугаар 105

Улаанбаатар  
хот

Хүүхдийн хоолны гуанэ нээж  
ажиллуулах тухай

1984-1985 оныг сурагчийн жил болгосонтой холбогдуулан Улаанбаатар хотын нийтийн хоолны удирдах газраас хүүхдэд зориулсан хоолны газрыг Октябрийн районы нийтийн хоолны трестийн харьяанд "Жаргалан", Сүхбаатарын районы нийтийн хоолны трестийн харьяанд "Бамбарууш" нэртэйгээр нээн амиллуулах гэж байгааг дэмжин, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

Нэг. "Жаргалан", "Бамбарууш" хүүхдийн хоолны газруудын хоолны үнийг ердийн гуанэны эдгээр тогтоосугай.  
нь: Хоёр. Хотын нийтийн хоолны удирдах газар /н. Урианхай/ - т даалгах нь: 1. Хүүхдийн хоолны газруудад хийх хоолны зорыг хүүхдийн хэрэгцээ, бие, насны онцлогт тохирсон, шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулж мөрдөх.

2. Хүүхдийн хоолны газруудын ажиллах дотоод журмыг нарийвчлан боловсруулж, батлан мөрдөж амилгах.

3. Хүүхдийн хоолны газруудын үйлчилгээг хүүхдийн хүмүүжилд нөлөөлөхүйц үлгэр шинэ зохион байгуулж, хүүхдийг нийтийн хоолны газраар үйлчилүүлж сургах, үйлчилгээний соёл түгээх бааз газар болгож амилгах.

Гурав. БНМАУ-ын Хөдөлмөр нийгэм хангамжийн улсын хорооны 1982 оны 400-р тогтоолын дагуу суудалд ноогдох нормативаас дутуу ажиллаж байгаа үйлчлэгч /хоол зөөгч/ 2-ыг нэмж баталж өгөхийг хотын санхүүгийн хэлтэс /н. Эрдэмбат/ - т даалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРГААНЫ ДАРГА *[Signature]* С. МӨНХЖАРГАЛ

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН ГИЧДИЙН  
ДАРГА *[Signature]*

Ч. ЖАМБАЛ